

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Пэрэнлэйдүндэв	Дугаар	L277
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Галт сум
Төрсөн газар	Галт сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хөөнгийн хүрээ, Бор бургасны хурал, Дуганы булан, Нарийний хүрээ, Улаан чулуутын хурал, Бумбатын хурал	Сүм хийдийн дугаар	ХӨГЛ 012, ХӨГЛ 014, ХӨГЛ 015, ХӨГЛ 013, ХӨГЛ 019
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007оны 6-р сарын 2	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Галт сумын Хөөнгийн хүрээ, Бор бургасны хурал, Бумбатын хурал, Дуганы булан, Нарийний хүрээ, Улаан чулуутын хурал

Мөнхбат: За ингээд Пэрэнлэйлүндэв гуай , та яг одоо тэр Хөөнгийн хүрээний нутгийн хүн байна, Хөөнгийн хүрээний тухай одоо өвөг дээдсээсээ мөн өөрөө багаасаа маш их мэдээллийг авсан гэж танай нутгийн хүмүүс бас хэлж ярьж таныг зааж өгсөн.Тэгэхээр хоёулаа асуулта эхлээ, тэгэхээр энэ Хөөнгийн хүрээ маань яг хэзээ үүссэн, хэдэн онд байгуулагдсан, мяар учир шалтгааны улмаас байгуулагдсан, анх байгуулагдаад одоо шашин номын үйл ажиллагаа эхэлж байх үедээ ямар ямар хурал ном хурдаг, ямар ямар хурал номын одоо дуган дацангуудтай, хэд орчим лам нартай ийм хүрээ хийдийн газар байсан юм бол оо?

Пэрэнлэйлүндэв: За Далай чойнхор вангийн ууган хүрээ Пунцагбалжирлангийн хийдийг анх арван гуравдугаар жарны гал үхэр жил буюу, 1716 онд Идэрийн голын зах Хөөнгийн аманд Бадмаанямбуу уулын өвөрт байгуулж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

арав орчим сүм хийдтэй, гурван зуу гаруй лам хуваргатай Жаавтын одоо хошууны ууган их томоохон хүрээ байсан юм гэнэ лээ.

Мөнхбат: За мэдээж Хөөнгийн хүрээ гэдэг энэ хүрээний гарал үүслийг танаас ингээд сонсож байхад бол маш олон ламтай, хурал номын газруудтай, бас тухайн үедээ Далай Чойнхор вангийн хошууны бараг анхных гэж хэлж болох ийм хүрээ байсан тухай сонсогдож байна.Тэгэхээр энэ хүрээнээс гарж төрсөн бүрхны шашны одоо том эрдэмтэй лам хуваргууд зөндөө байсан нь мэдээж, эндээс нутгийн олны дунд домог болж үлдсэн зарим эрдэмтэй лам нарын эрдэм чадлын талаар одоо дурсан санахгүй юу?

Пэрэнлэйлүндэв: За Хөөнгийн хүрээнд Гүмбэн ранжамба гэж багш байсан.Тэр хүн гучин найман онд баригдаад явсан юм гэнэ лээ.За мөн хүрээнээс өмнө таалал төгссөн юм гэнэ лээ, Тэлээгийн хувилгаан гэж.

Бор бургасны хурал

Мөнхбат: Ингээд сумын өндөр настан, бидэнд газарчилж яваа Пэрэнлэйлүндэв гуайгаас Бор бургасны хурал хэмээх энэ газар байсан, одоо бурхан номын үйл ажиллагаа явуулж байсан энэ хоёр дуганы үүх түүхээс сонирхож асууя.

Пэрэнлэйлүндэв: Далай Чойнхор вангийн хошууны зүүн сумын нутаг, энэ Бор бургасны энэ Ширээгийн дэнж дээр Бор бургасны дуган гэж байсан байгаа юм аа.

Аа энэ дуганы гол шүтээн нь Вандан Лхам буюу энэ нутгийнхан Бор Лхам гэж бурхан тахиж байжээ.Энэ Бор Лхам гэдэг бурхан бол Вандан Лхам бурхныг далай ламаар аравнайлуулж ирсэн.Тэгээд дээрээ будаг тогтохгүй байсан учраас Бор Лхам гэж нутгийнхан нэршиж байсан гэдэг түүхтэй юм.Энэ бурханд хүмүүс өвчтэй хүмүүсээ даатгаж хадаг өргөл тавихад сэхэхгүй байсан хүний хадаг нь тогтдоггүй байсан ийм алдартай бурхан гэдэг юм аа.За энэ бурхныг одоо Мөрөнгийн төвд байгаа Гэндэнпүрэвийнд байдаг гэж ингэж ярьдаг юм.За энэ хүрээ бол гучин долоон оны эсэргүүнээр үстгагдаж энэ Бор бургасны дуганд энэ хавийн лам нарыг авчирч олон лам нарыг алсан.Аа энэ лам нарын шарилыг бол Маахав гэдэг хүнээр одоо хар хүнээр зайлуулаад, тэр хүнийг одоо хэргээс мулталж байсан түүхтэй бөгөөд тэр хүн бол саяхан болтол одоо амьд мэнд амьдарч байсан юм аа, Маахав гуай. За ийм л ерөнхийдөө түүхтэй газар даа.

Мөнхбат: За баярлалаа.

Бумбатын хурал

Мөнхбат: За манай судалгааны баг Хөвсгөл аймгийн Галт сумын гуравдугаар багийн нутаг Бумбатын ам хэмээх газар ирээд байна. Энэ Бумбатын ам гэдэг газр Академич Ренчин гуайн монголын сүм хийдийн туурь балгасын жагсаалтад орсон Далай Чойнхор вангийн хошууны хурал номын газруудын нэг болох Бумбатын дуган хэмээх ийм хурал номын газрын туурин дээр ирж байна.Тэгээд нутгийн өндөр настан Пэрэнлэйлүндэв гуайтай уулзаж энэ Бумбатын дуганы талаар одоо ямар мэдээлэлтэй байгааг нь сонирхсон юм аа.

Пэрэнлэйлүндэв: За Бумбатын дуган бол байгуулагдсан, энэ хүрээний лам нар цуглаж хайлан хурдаг байсан гэж сонссон юм аа.Энэ хүрээ бол тэгээд л гучин долоон онд үстгагдаж, Энэ Бумбатын дуган.Энэ дээр Хөвсгөл аймгийн Идэр сум анх байгуулагдан төвлөрч энд бага сургууль, худалдаа бэлтгэл ангийн анхны нэгж байрлаж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байгаад тэгээд сүүлдээ эндээсээ нүүдэллэсэн.Одоо бол ингээд айлын зуслангийн юм байгаа юм аа.Энэ Бумбатын амны ойролцоо одоо Наранбулагийн овоо гэж байсныг сүүлийн үед, ерэн оноос одоо хойш сэргээж энийг жил болгон тахиж байна.Энэ урд талдаа байгаа ууланд одоо Галтын овоо гэж байгааг нутгийн ахан дүүс хуран цугларч одоо ийм тахилгатай байгаагаас өөр бол энэ дээр номын хуучин ийм юм байхгүй. Ул мөр байхгүй, чухам ийм болчихсон байгаа газар юм аа.

Мөнхбат: За баярлалаа.

Дуганы булан

Мөнхбат: За манай судалганы багинхан Хөвсгөл аймгийн Галт сумын төвөөс зүүн тийш жаран зургаа орчим км зайд Идэрийн голын урд бие Сайрын эх хэмээх модот өндөр уулын ард Дуганы булан хэмээх газар ирээд байна.Ингээд Дуганы булан хэмээх газар академич Ренчин гуайн жагсаалтанд ороогүй байгаа Далай чойнхор вангийн буддын шашны бас хүрээ хийдийн нэг болох гурван ч дуганы туурин дээр одоо ирээд байж байна.Ингээд энэ Дуганы булан хэмээх газрын байсан хүрээ хийдийн ор туурийн тухай нутгийн өндөр настан Пэрэнлэйлүндэв гуайгаас зарим тодруулгыг хийсэн юм аа.

Пэрэнлэйлүндэв: Далай чойнхор вангийн хошууны зүүн сумын энэ доод зах буюу одоогийн Хөвсгөл аймгийн Галт сумын нутаг буюу хамгийг зүүн захад Дуганы булан, одоо Тэлээгийн аманд Идэрийн захад тэр Дуганы булан гэж байгаад энэ гучин долоо, найман оны эсэргүү хөдөлгөөний үед үрэгдэж яасан юм аа.Энэ хамгийн захын одоо хүрээ хийд байсан учраас одоо цөөн ламтай ийм байсан болов чиг энэ Тэлээгийн хувилгаан гэж алдарт тийм хүн байсан байгаа юм.далай Чойнхор вангийн хошууны Яргийн халзан нэртэй Богдын сор залж байсан тийм лам энд, энэ хүрээнд шавилан сууж байсан ийм түүхтэй юм билээ.Тэр юуны хүрээн дээр та нар очиход энэ Хувилгаан багш гээд зураг нь энд тэндгүй байдаг юм аа.

Мөнхбат: Тэгэхээр энэ дээр нэг ийм, жагсаалтан дээр нэг ийм нэр байгаа юм аа. Энэ л одоо миний бодлоор бол, энэ Ренчин гуайн жагсаалтанд Хөвсгөл аймгийн Галт сумын нутагт байгаа, Идэрийн голын орчим нутагт байгаа Тээлийн хурал гэсэн нэг ийм нэр орж ирсэн байгаа юм.Тэгэхээр энэ бараг Тэлээгийн хурал ч гэсэн ийм нэртэй, мөн байж болох тал байна уу, үгүй юу тийм ээ.Одоо энэ Ренчин гуайн зүүн дөчин долоо гэсэн дугаар дээр байгаа юм.Хөвсгөл аймгийн Галт сумын нутаг, одоо зүүн дөчин долоо гэсэн жагсаалтан дээр бүртгэгдсэн Тээлийн хурал гээд орчихсон байгаа юм.Идэрийн голын ойр орчимд байна гээд.Та энэ дээр одоо санал нийлэх барих юм байна уу, үгүй юу? Таны хувьд?

Пэрэнлэйлүндэв: Тэгэхлээр энэ Тэлээгийн ам гэдгийн Тээлийн ам гэж одоо тэгж ташаарч бичигдсэн байж болох юм.Энэ Галт сумын нутагт бол одоо Тээлийн ам гэж газар байхгүй ээ.Энэ бол Тэлээгийн амны тэр Дуганы булангийн дуган байсан байж л таарах байх аа.

Мөнхбат: За баярлалаа, таньд.

Нарийний хүрээ

Мөнхбат: За бид нар Галт сумын төвөөс арван найман км-ын орчим зайд байдаг, тус сумын гуравдугаар багийн нутаг Нарийны ам гэдэг газар ирээд байна.Энэ Нарийны ам гэдэг газар байгаа энэ хүрээний туурь бол академич

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ренчин гуайн жагсаалтанд орсон ийм хүрээ. Мөн л одоо Далай Чойнхор вангийн хошууны бурхан номын бас нэг томоохон төв байсан ийм газар байна. За энэ дээрээс ингээд ажиглаж байхад үүн дээр арван тав, арван наймын хэмжээтэй голын цогчин дуган байсан болов уу гэж таамагламаар энэ том дуганы туурийн урд талд найм наймын хэмжээтэй дөрвөн ширхэг жижиг дуганы туурь байх юм. Тэгээд ерөнхийдөө дуганы тууриуд маш ихээр баларсан эвдэрсэн, одоо газрын хөрснөөс дугануудын суурь болох чулуунууд л одоо цувж үлдсэн, аа бусад хэсгүүд бол бараг газрын хөрстэй тэгширч, эвдэрсэн ийм байдалтай байна. За ингээд энэ хүрээний тухай сонссон дуулсан, ийм одоо түүх судраас нь хэлж ярьж өгнө үү хэмээн одоо бидэнтэй хамт газарчилж яваа Галт сумын өндөр настан Пэрэнлэйлүндэв гуайтай уулзаж байна аа.

Пэрэнлэйлүндэв: За одоогийн Хөвсгөл аймгийн Галт сумын гуравдугаар багийн нутагт Салбартын голд байгаа Нарийны хүрээ бол гучин найман оны эсэргүү хөдөлгөөнд одоо устгагдаж, шатаагдсан ийм хүрээ юм аа. За энэ хүрээний одоо хамгийн сүүлийн үнзад Гомбожвын Дамбийням гэдэг хүн бол одоо лам нар, тэр үеийн лам нар зарим нь баригдаж, зарим нь алагдаж, одоо зарим нь хар болж цэрэгт явж ингэж байх үед тэр хүн бол одоо хар болж сүүлдээ мал тариалангийн яамны орлогч сайд, шашны хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан ийм хүн юм аа. Эдний одоо үр хүүхдүүд, төрөл төрөгсөд болвол Улаабаатар хотод амьдран суудаг юм. Энэ байдлаас үзэхэд Дамбийням гуай бол одоо Галтынхны бол бахархаж явмаар их эрдэмтэн ийм хүн байсан нь бол тодорхой, амьд гэрч болон үлдсэн юм байгаа юм аа.

Мөнхбат: Тэгэхээр тухайн цаг үедээ энэ Нарийны хүрээнд хурал номын үйл ажиллагаа ид цэцэглэн мандан бадарч байх цаг үед энэ хүрээнд одоо хэдэн лам нар сууж байсан бол, ямар бурхан шүтээн одоо голлож тахиж шүтдэг байсан юм бол энэ талаар одоо таньд болон танай нутгийн өвөг дээдсийн дунд яригдаж уламжлагдаж ирсэн ийм мэдээ баримт байх юм болов уу?

Пэрэнлэйлүндэв: За Нарийны хүрээнд бол одоо зуугаад лам оршин сууж байсан гэсэн байх аа. Энэ хүрээнд шавилан сууж байсан мөн Лувсансодов гуай гэдэг хүн байсан. Тэр хүнээс одоо бас энэ талаар товч сонсож мэдээ авч байсан юм байгаа юм аа. Энэ хүрээний сахиус гол шүтээн бол Дамдинчойжил байсан гэж ярьдаг байсан байх аа. Лувсансодов гуай бол одоо энэ сумын төвд байгаа сүм хийд одоо босголцоод саяхан ингээд таалал төгссөн. Энэ хүрээний одоо хамгийн сүүлийн шавь нь байсан юм байгаа юм аа.

Мөнхбат: За баярлалаа, таньд. Тэгэхээр бид нар ингэж үзэж байна л даа. Хөвсгөл аймгийн Галт сумын гуравдугаар багийн нутаг буюу бид нар энд хүрэлцэн ирээд байгаа энэ Салбартын гол дагуу хөндий энэ урт уудам жалга болвол зөвхөн Нарийны хүрээ төдийгү, мөн одоо Ренчин гуайн жагсаалтанд тэмдэглэгдсэн Улаан чулуутын хурал хэмээх хурал номын газар эндээс одоо дээшээгээ гурваас дөрөв орчим км газарт буурь туурь нь байсан байх юм. За мөн нөгөө талаар энэ хөндий жалга, зөвхөн энэ Нарийны хүрээ, Улаан чулуутын хурлын газраас төдийгүй мөн одоо энэ жалгын аманд Галтын буган чулуун хөшөө гэж алдаршсан зургаан буган чулуу хөшөө бий, Түрэгийн. За мөн энэ яг энэ бид нарын зогсож байгаа Нарийны хүрээний тууриас баруун тийшээ дөчөөд метр газарт өндрөөсөө жаран см орчим өндөртэй, зузаан нь 23-25 см, өргөн нь дөч орчим см-ын өргөнтэй тийм боржин чулуун дээр эрэгтэй, эмэгтэй хоёр хүний одоо нүүрийн хэсгийг маш тод урнаар гаргаж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ингэж сийлж үлдээсэн байх юм.Тэгэхээр энийг бол одоо бид нарын өнөөдрийн мэдэж байгаагаар монголын түүх соёлын дурсгалд одоо бүртгэгдээгүй, түүхч эрдэмтдийн анхааралд одоо өртөгдөөгүй ийм одоо хоёр бага шиг хүн чулуун хөшөө гэж одоо хэлж болохоор ийм хөшөө дурсгал энд байна.За энэ байдлаас нь ажиглахад эмэгтэй хүний нүүр царай дүрсэлсэн тэр чулуун хэсгийн зураас, одоо нүд, хөмсөг, сормуус, ам , хамр, чих, чихний ээмэг зэрэг бол одоо маш нарийн ингэж үлджээ.Харин одоо байгалийн он цагийн салхинд тэр эрэгтэй хүний дүрс бүхий хөшөө бол одоо бас нэлээн баларсан ийм байдалтай харагдаж байна.Тэгэхээр энэ эмэгтэй эрэгтэй хоёр хүн чулууг ол нутгийн ард иргэд ноён хатан хоёр гэж нэрлэдэг бололтой.Тэгэхээр энэ ноён, хатан хоёр бүхий хүн чулуун хөшөө энэ Нарийны хүрээ хоёр бол бас түүхэнд хоорондоо ямар нэгэн уялдаа холбоотой байж болох юм аа гэж бид нар ингэж үзэж байна аа.За мөн Нарийны хүрээний эргэн тойронд таваас долоон км-ын орчимд үндсэндээ таваас зургаан хиргисүүрүүд байна. Энэ хиргисүүрүүд бол судлагдаагүй, ийм бүрэн бүтнээрээ байгаа ийм хиргисүүрүүд байгаа юм байна аа.

Улаан чулуутын хурал

Мөнхбат: За бид нар Галт сумын гуравдугаар багийн нутаг Галт сумаас дээшээ нэг хорин хоёр км орчим , Салбартын уулын ард байх Улаан чулуутын хурлын туурин дээр байна.За тэгэхээр Улаан чулуутын хурлын тухай академич Ренчин гуайн жагсаалтанд орсон.За Улаан чулуутын хэмээх энэ туурь бол нэн эртний энэ хурал хийдийн түүх шастир, энэ хурал номын үйл ажиллагаа хэрхэн яаж явагдаж байсан тухай чухам хэдэн лам нар байдаг байсан, хэдий үед мөхсөн за мөн ямар бурхан шүтээнийг голлож тахидаг байсан, ямар уншлага одоо байнга уншлага явуулж байсан тухай тодорхой мэдээллэх боломжтой хүн энэ нутагт одоо бид нартай тааралдсангүй.За эндээс харахд бол Улаан чулуутын хурал ямар ч байсан түүхийн тодорхой нэгэн хэмжээнд ямар нэгэн хурал номын үйл ажиллагаа явуулж байсан бололтой. Гурваас дөрвөн дацан, сүм хийдийн туурь байсан гэж одоо нутгийнхан ярьж байна.Одоо бол одоо мэдэгдэж байгаа, мэдэгдэх боломжтой ийм юм алга.Аа мөн одоогоос нэг гуч гаруй жилийн тэртээ энд байсан хоёр дуганы барилгын үлдэгдлийг хувь хүмүүс аваад одоо өвөлжөө хаваржаандаа аваачиж байшин, пүнз, амбаар барьсан гэж нутгийнхан ярьж байна аа.За мөн Улаан чулуутын энэ туурин дээрээс Салбартын голын тэртээ Бөөгийн хясаа гэдэг газар байдаг гэж байна. За Бөөгийн хясаа гэдэг энэ газрыг зүгээр нэрнээс нь аваад үзэхэд бол бас ямар нэгэн өөрийн гэсэн онцлог түүхтэй энэ Буддын шашны бүс нутагт бас одоо энэ Бөөгийн хясаа гэсэн ийм газар байгаа нь бас анхаарал татахгүй байхын аргагүй.Гэсэн ч бас одоо энэний түүх домгийг ярих хүн бид нартай бас төдийлэн одоо тааралдсангүй ээ. За нөгөө талаар мөн одоо энэ Улаан чулуутын хийдийн туурийн орчимд маанийн үсэг одоо цохиж сийлж бичсэн хад хоёроос гурав байдаг байсан гэж нутгийнхан ярьж байна.Гэсэн ч одоо тэд он цагийн элэгдэлд, түүхийн нугачаанд одоо энэ маанийн үсэг хаднаасаа бүр мөсөн арилж баларсан байна аа.